



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 24 өдөр

Дугаар А/25

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, 65 дугаар зүйлийн 65.1.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1, 34.1.2, аймгийн Онцгой комиссын 2024 оны 1 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд өвөлжилт хүндэрч зудын эрсдэлийн үнэлгээгээр 7 буюу зудын эрсдэл ИХ гэсэн үнэлгээтэй байгаа нөхцөл байдлыг харгалзан аймгийн аюулгүйн нөөцөд өвсний нөөцийг бүрдүүлэх зорилгоор 60,000,000 (Жаран сая) төгрөгийг Мал хамгаалах сангаас зарцуулсугай.

2. Аймгийн аюулгүйн нөөцөд өвс бүрдүүлэх ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг Худалдан авах ажиллагааны газар (Б.Должинсорогдог)-т даалгасугай.

3. Худалдан авах ажиллагааны үйл явц, үр дүн харгалзан Мал хамгаалах сангаас батлагдсан хөрөнгийг зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Э.Улам-Өсөх), Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Э.Анхцэцэг) нарт тус тус зөвшөөрсүгэй.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М. Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П. ЛХАГВАЖАВ

